



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 06 сарын 13 өдөр

Дугаар А/421

Арвайхээр

Эрх шилжүүлэх тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5, 14.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны “Аймгийн 2019 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” 11/06 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2019 оны төсвийн жилд хийгдэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт”-ын 5 дугаар заалт дахь Хархорин суманд төрийн үйлчилгээний автомашины шинэчлэл хийх 40000 000 (дөчин сая) төгрөгийн худалдан авах ажиллагаа зохион байгуулах эрхийг Хархорин сум дахь сум дундын Прокурорын газар (С.Баасандорж)-т шилжүүлсүгэй.

2. Санхүүжилтийг хуваарийн дагуу олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100699